

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 10 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 281

Улаанбаатар хот

┌ Тусгаарласан хувьцааны хугацааг сунгах тухай ┐

“Гермес Центр” ХК-ийн анх нийтэд хүргэсэн үнэт цаас гаргах тухай танилцуулгад тусгагдсан төсөл нь төлөвлөсний дагуу хэрэгжээгүйгээс уг компанийн жижиг хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах нөхцөл үүсч болзошгүйг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Гермес центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчид болох иргэн Д.Зоригтын өмчлөлийн 38.205.800 ширхэг, иргэн М.Түмэнжаргалын өмчлөлийн 20 892 438 ширхэг энгийн хувьцааг 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд тусгаарлахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН